

01.

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙНХУРАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.10.14

№19

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1.	Орон нутгийн өмчит байгууллагуудыг өөрчлөн байгуулах тухай	Б.Эрдэнэбаяр	Р.Пүрэвдорж	Тогтоол 81
2.	Тогтоолд нэмэгт өөрчлөлт оруулах тухай/ эргэлтийн эмийн сан/	Ц.Туяа	Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс	Тогтоол 82
3.	Ойн тэмдэглэх тухай	Г.Ундрам	Д.Давдаадорж	Тогтоол 83
4.	"Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай	Л.Ганхуяг	З.Мөнхнасан	Тогтоол 84
5.	Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх	Б.Итэшмаа		Тэмдэглэл

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 81

Есөнбулаг сум

Орон нутгийн өмчит байгууллагуудыг
өөрчлөн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25-р зүйлийн 25,1 дүгээр заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Алтай хотын Тохижилт үйлчилгээний газрын Ногоон байгууламжийн тасгийг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон Сум дундын ойн ангид шилжүүлсүгэй.

2. Ногоон байгууламжийн тасаг шилжиж байгаатай холбогдуулан аймгийн Сум дундын ойн анги болон Алтай хотын Тохижилт үйлчилгээний газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.


3. Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар болон Алтай хотын Тохижилт үйлчилгээний газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгэлтэй хавсралтад дурьдсан хөрөнгийг аймгийн Сум дундын ойн ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

4. Алтай хотын Тохижилт үйлчилгээний газарт бүртгэлтэй, Сум дундын ойн анги ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгийг гурвалсан гэрээ байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Л.Ганхуяг)-д даалгасугай.

ДАРГА Л.Батжаргал Л.БАТЖАРГАЛ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 дугаар сарын 21-ний
өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖИХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хөрөнгө бүртгэлтэй байгаа байгууллагын нэр	Шилжүүлж авах байгууллагын нэр	Хөрөнгийн үнэ /Төгрөг/	Нийт хураамтлагдсан элэгдэл /Төгрөг/	Үлдэгдэл өртөг /Төгрөг/	Блансад тусгах үнийн санал /Төгрөг/
1	Dong feng 7тн усны машин /21-24 ГАУ/	Тохижилт үйлчилгээний газар	Сум дундын ойн анги	56 000 000	49777777,8	6222222,2	6222222,2
2	Dong feng Defac 5тн усны машин /14-68 ГАА/	Есөнбулаг сумын ЗДТГ	Сум дундын ойн анги	41 000 000	40999999,68	0,32	100000
3	Иж бүрдэл трактор	Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	Сум дундын ойн анги	7600100	7600100	0	50000
4	Шүтээний өндөрлөгийн баруун урд байрлах цэцэрлэгт хүрээлэн						
	ЭВЦ-6-4-190 насос бүхий гүний худаг	Тохижилт, үйлчилгээний газар	Сум дундын ойн анги	10000000	8375000.03	1624999.97	1624999.97
	Блокон хашаа	Тохижилт үйлчилгээний газар	Сум дундын ойн анги	1988454,30	745670.34	1242783.96	1242783.96
	Торон хашаа	Тохижилт үйлчилгээний газар	Сум дундын ойн анги	15593565,62	1949195.7	13644369.92	13644369.92
	Сүүдрэвч	Тохижилт үйлчилгээний газар	Сум дундын ойн анги	329500,00	315770.8	13729.2	13729.2
Нийт дүн							16525883.05



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 82

Есөнбулаг сум


Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.1 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 63 дугаар тогтоолын хавсралтад Баян-Уул, Шарга сумдын эмийн эргэлтийн санг нэмж оруулан худалдах хөрөнгийн үнийг хавсралтаар тогтоон эзэмшигчдэд нь худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоолын хавсралтаас Баян-Уул сумын эмийн эргэлтийн сангийн 11755957,6 төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 395000 төгрөгийн үндсэн хөрөнгө, Шарга сумын эмийн эргэлтийн сангийн 6694850 төгрөгийн эргэлтийн хөрөнгийг хасахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 дугаар сарын 17-ний
өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт



ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Эргэлтийн хөрөнгө				Эргэлтийн бус хөрөнгө			Өглөг	Шилжүүлэх хөрөнгийн дүн	Аймгийн орон нутгийн эмчийн газрын худалдах үнийн санал	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлаас тогтоосон үнэ
		Мөнгөнх өрөнгө	Эм, бараа	Авлага	Дүн	Тавилга	Биет бус хөрөнгө	Үндсэн хөрөнгийн дүн				
0	1	2	3	4	5=2+3+4	6	7	8	9	10	11	12
1	Баян-Уул ЭЭС	3254028	8872535	4536000	16662563	230000	165000	395000	4906605.6	12150957.5	2,200,000.0	2,200,000.0
2	Шарга ЭЭС	19327	9119380	336430	9475137			395000	2780287	7089850	2,198,000.0	2,198,000.0

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Ашиглах хугацаа			Хөрөнгийн			Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шинээр үнэ тогтоож цаашид ашиглах
			Анх авсан	Ашиглах жил	Дуусах он	тоо ширхэг	нэг бүрийн үнэ	нийт үнэ			
Баян-Уул сумын ЭЭС								0	0		
1	Хөргөгч	ш	2000	10	2010	1	230000	230000	-230000	0	230000
2	Программ	ш	2014	5	2019	1	300000	300000	-300000	0	165000
	Нийт дүн							530000	-530000	0	395000



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 83

Есенбулаг сум

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.14 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймагт Иргэний Нийгмийн Нэгдсэн Зөвлөл үүсч хөгжсөний 20 жилийн ойг 2019 оны 10 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтсугай.
2. Ойг тэмдэглэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
3. Төр, хувийн хэвшил, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн гэрээг дүгнэж, ойн арга хэмжээг зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Даваадорж)-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



ОЙГ УГТСАН БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Даваадорж -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Г.Ундрам- Аймгийн ИННЗ-ийн тэргүүн

Ойн бэлтгэл хангах гишүүд:

О.Даваажаргал-ХАҮТ-ын ажилтан

Я.Эрхэмбаяр-"Монгол даатгал" компаний захирал

Д.Оюунчимэг-ХААХХ-ны дэд тэргүүн

Ойн хөрөнгө, санхүү хариуцсан гишүүд:

Ч.Жаргалсайхан-Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангий хэлтсийн дарга

Л.Сумаахүү- Аймгийн ҮЭХ-ны дарга

Г.Оюунчимэг-АОЭХ-ны дэд тэргүүн

Ойн баярын арга хэмжээ зохион байгуулах гишүүд:

Д.Баттайван- Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Алтайбаатар- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн Бодлогын хэлтсийн дарга

А.Баасандаш- Аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах мэргэжилтэн

Э.Бямбаа- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн Бодлогын хэлтсийн мэргэжилтэн

М.Сувдмаа-ХАҮТ-ын ажилтан

Ц.Ачитмаа-Гүүрэн гарц ТББ-ын Тэргүүн

Л.Ариунаа- Монгол Оршихуйн ухаан ТББ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 34

Есөнбулаг сум


“Алтай орон сууцны корпораци” аж ахуйн
тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3- ын “ж” дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус аймагт 120 айлын орон сууц ашиглалтад орсонтой холбогдуулан түрээсийн орон сууцыг борлуулах, түрээсээр өмчлүүлэх, орон сууцны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Алтай орон сууцны корпораци” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулж, дүрмийг 1 дүгээр хавсралтаар, бүтэц, зохион байгуулалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдуулан тавилга эд хогшил, техник тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)- д даалгасугай.

3. “Алтай орон сууцны корпораци” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, гэрээ байгуулан, биелэлтийг хангуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)- т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТЖАРГАЛ

